



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДАА-2024/02/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр

Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Аудитын менежер У.Батсүрэн

Утас: 70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn

Ахлах аудитор С.Батцэцэг

Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитор Н.Отгонцэцэг

Утас: 70378845 Цахим хаяг: otgontsetsegn@audit.gov.mn

Дархан-Уул аймаг

2024 он



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дугаар баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.02.19 № 06
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Эрүүл мэндийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тус байгууллагын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.5 дахь хэсэгт заасны дагуу 164 албан хаагчид 1,735,861.1 мянган төгрөгийн хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж олгосныг санхүүгийн тайланд толилуулж, тодруулсан байна.

Аудитын гол асуудал

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоож, 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс олгож эхэлсэн байна. Мөн Засгийн газрын 2023 оны 52 дугаар тэмдэглэлээр цалингийн сангийн хэмнэлтээс ажилтны ажлын үр дүнг нь харгалзан үндсэн цалингийн 17-100 хувиар тооцож урамшуулал олгожээ.

Бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Эрүүл мэндийн газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилтын хүрээнд 131 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 93 хувиар дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

009020026

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

АГУУЛГА

1. ХАРААТ БҮС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	14
3.3 Санхүүгийн тайлангалын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.5.1 Төсвийн төлөвлөлт	15
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	15
3.5.3 Нэмэлт төсөв	16
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.5.1 Завсрын аудитын талаар	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5.1 Төлбөрийн акт	18
5.2 Албан шаардлага	19
5.3 Зөвлөмж	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин
ХӨСҮТ	Халдварт өвчин судлалын үндэсний төв
ЭМЯ	Эрүүл мэндийн яам

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	619,848,424.88	605,421,123.21
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	50.00	-
33	АВЛАГА	-	1,472,650.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	1,472,650.00
35	БАРАА МАТЕРИАЛ	619,848,374.88	603,948,473.21
351	Түүхий эд материал	486,234,944.06	450,585,088.68
35110	Тусгай зориулалттай материал	198,000.00	3,266,000.00
35130	Эм боох материал	486,036,944.06	447,319,088.68
354	Хангамжийн материал	133,613,430.82	153,363,384.53
35410	Бичиг хэргийн материал	3,764,708.00	4,898,248.00
35420	Аж ахуйн материал	120,606,642.82	142,334,292.53
35430	Сэлбэг хэрэгсэл	9,039,000.00	5,659,000.00
35440	Түлш, шатах тослох материал	203,080.00	471,844.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,069,718,687.29	2,906,305,486.16
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,069,718,687.29	2,906,305,486.16
392	Биет хөрөнгө	2,782,554,687.29	2,619,321,486.16
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,566,340,965.46	2,566,340,965.46
39202	Хуримтлагдсан элэгдэл	(208,455,789.93)	(292,162,417.41)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	136,300,000.00	136,300,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(49,027,083.43)	(69,464,583.43)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	460,249,909.90	469,960,609.90
39206	Хуримтлагдсан элэгдэл	(192,070,610.97)	(247,565,146.63)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	95,833,488.66	95,833,488.66
39208	Хуримтлагдсан элэгдэл	(38,954,624.40)	(51,899,862.39)
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,850,000.00	7,850,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(4,310,000.00)	(4,670,000.00)
39217	Ном	8,798,432.00	8,798,432.00
393	Биет бус хөрөнгө	287,164,000.00	286,984,000.00
39301	Програм хангамж	680,000.00	680,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(20,000.00)	(200,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	286,504,000.00	286,504,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,689,567,112.17	3,511,726,609.37
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	7,990,150.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	7,990,150.00
413	Өглөг	-	87,400.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	7,902,750.00
4136	Бусад өглөг	-	200,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	7,702,750.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,689,567,112.17	3,503,736,459.37
51	Засгийн газрын хувь оролцоо	3,689,567,112.17	3,503,736,459.37



511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	759,157,825.15	759,157,825.15
51101	Өмч: - төрийн	759,157,825.15	759,157,825.15
512	Хуримтлагдсан үр дүн	347,343,467.80	161,512,815.00
51210	Өмнөх үеийн үр дүн	347,343,467.80	347,343,467.80
51220	Тайлант үеийн үр дүн	-	(185,830,652.80)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,583,065,819.22	2,583,065,819.22
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>3,689,567,112.17</u>	<u>3,511,726,609.37</u>



2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,335,430,024.49	4,469,928,298.13
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,374,131,241.46	682,511,876.13
120	Нийтлэг татварын бус орлого	1,874,434,722.46	680,300,876.13
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,874,434,722.46	680,300,876.13
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,445,000.00	735,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,093,904.00	16,411,960.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,855,895,818.46	663,153,916.13
122	Тусламжийн орлого	499,696,519.00	2,211,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	499,696,519.00	2,211,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,961,298,783.03	3,787,416,422.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,748,160,100.00	3,649,119,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,748,160,100.00	3,649,119,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	213,138,683.03	138,296,822.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	33,024,509.03	22,165,230.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	69,596,059.00	48,613,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	104,003,945.00	67,518,592.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,514,170.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,063,564,148.01	4,534,407,414.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,063,564,148.01	4,534,407,414.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,532,419,376.11	2,453,865,967.65
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	939,794,711.00	1,271,809,256.94
210101	Үндсэн цалин	635,790,494.00	797,509,621.69
210102	Нэмэгдэл	124,845,715.00	284,663,192.04
210103	Унаа хоолны хөнгөлөлт	66,234,000.00	60,577,631.67
210104	Урамшуулал	112,924,502.00	129,058,811.54
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	115,832,267.40	156,144,909.82
210201	Тэтгэврийн даатгал	79,900,386.87	107,764,437.70
210202	Тэтгэмжийн даатгал	9,518,036.40	12,964,246.14
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,463,229.46	10,062,682.40
210204	Ажилгүйдлийн даатгал	1,722,782.78	2,304,868.95
210205	Эрүүл мэндийн даатгал	17,227,831.89	23,048,674.63
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,276,658.84	65,526,215.90
210301	Гэрэл, цахилгаан	15,610,558.56	21,958,375.52
210302	Түлш, халаалт	20,927,878.62	24,442,399.24
210304	Байрны түрээс	5,288,200.00	5,834,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	70,796,342.19	54,231,553.96
210401	Бичиг хэрэг	11,016,935.00	6,089,960.00
210402	Тээвэр, шатахуун	19,677,236.00	13,470,628.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,319,583.17	10,616,454.54

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,495,100.00	2,786,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	28,287,488.02	21,268,111.42
2105	Норматив зардал	992,813,690.52	588,602,282.78
210501	Эм, балдвал, эмнэлгийн хэрэгсэл	991,483,890.52	583,429,682.78
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,329,800.00	5,172,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	36,804,710.00	9,549,990.00
210601	Батаж, техник, хэрэгсэл	4,196,745.00	1,168,290.00
210604	Урсгал засвар	32,607,965.00	8,381,700.00
2107	Томилголт, зочны зардал	13,882,950.00	7,227,338.00
210702	Дотоод албан томилголт	13,882,950.00	7,227,338.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	42,327,837.45	42,588,262.52
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	31,559,129.45	34,172,869.44
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,123,520.00	627,828.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,570,000.00	1,092,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	272,254.00	355,386.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	99,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,456,366.00	3,072,620.65
210807	Газрын төлбөр	861,008.00	813,008.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,386,560.00	2,355,300.43
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	269,890,208.71	259,658,807.73
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	122,297,091.25	85,561,806.60
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,741,600.00	973,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	145,851,517.46	173,123,901.13
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,531,144,771.90	2,080,541,447.28
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,298,956,500.00	1,756,478,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,084,943,800.00	1,063,124,800.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,145,582,700.00	679,253,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	68,430,000.00	14,100,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	232,188,271.90	322,590,197.28
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	232,188,271.90	322,590,197.28
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,271,865,876.48	(64,479,116.80)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	928,789,835.44	121,351,536.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	928,789,835.44	121,351,536.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(928,789,835.44)	(121,351,536.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	343,076,041.04	(185,830,652.80)



2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Тзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>3,984,837,887.03</u>	<u>3,804,563,382.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	18,539,104.00	17,146,960.00
120	Нийтлэг татварын бус орлого	18,539,104.00	17,146,960.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	18,539,104.00	17,146,960.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,445,000.00	735,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,094,104.00	16,411,960.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>3,966,298,783.03</u>	<u>3,787,416,422.00</u>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,748,160,100.00	3,649,119,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,748,160,100.00	3,649,119,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	218,138,683.03	138,296,822.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	33,024,509.03	22,165,230.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	69,596,059.00	48,613,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	109,003,945.00	67,518,592.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,514,170.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>3,970,008,137.03</u>	<u>3,797,063,732.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>3,970,008,137.03</u>	<u>3,797,063,732.00</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>1,438,863,365.13</u>	<u>1,723,039,784.72</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	939,794,711.00	1,271,809,256.94
210101	Үндсэн цалин	635,790,494.00	797,509,621.69
210102	Нэмэгдэл	124,845,715.00	284,663,192.04
210103	Унаа хоолны хөнгөлөлт	66,234,000.00	60,577,631.67
210104	Урамшуулал	112,924,502.00	129,058,811.54
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	115,832,267.40	156,144,909.82
210201	Тэтгэврийн даатгал	79,900,386.87	107,764,437.70
210202	Тэтгэмжийн даатгал	9,518,036.40	12,964,246.14
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,463,229.46	10,062,682.40
210204	Ажилгүйдлийн даатгал	1,722,782.78	2,304,868.95
210205	Эрүүл мэндийн даатгал	17,227,831.89	23,048,674.63
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,276,658.84	65,526,215.90
210301	Гэрэл, цахилгаан	15,610,558.56	21,958,375.52
210302	Түлш, халаалт	20,927,878.62	24,442,399.24
210303	Цэвэр, бохир ус	8,450,021.66	13,291,441.14
210304	Байрны түрээс	5,288,200.00	5,834,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	51,803,297.17	39,206,604.54
210401	Бичиг хэрэг	7,008,450.00	5,616,800.00
210402	Тээвэр, шатахуун	17,202,404.00	13,775,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,319,583.17	10,616,454.54
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,276,000.00	1,425,000.00

ХТ05436@0022099

210406	Бага үнэтэй, турган элэгдэх, агуйн эд зүйлс	15,996,860.00	7,773,350.00
2105	Норматив зардал	53,442,585.00	15,475,420.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	53,442,585.00	13,197,520.00
210503	Нормын хувцас, зөөлөн адлал	-	2,277,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	34,571,065.00	7,541,750.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,150,000.00	1,822,800.00
210603	Хөдөлмөр хангаалтын хэрэгсэл	412,700.00	959,100.00
210604	Урсгал засвар	33,008,365.00	4,759,850.00
2107	Томиллолт, зочны зардал	13,882,950.00	7,227,338.00
210702	Дотоод албан томиллолт	13,882,950.00	7,227,338.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	45,642,499.45	44,278,587.52
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	33,511,351.45	36,264,494.87
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,123,520.00	627,828.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,570,000.00	1,092,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	272,254.00	355,386.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	99,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,471,366.00	3,072,620.65
210807	Газрын төлбөр	861,008.00	813,008.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	50.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,734,000.00	1,954,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	133,617,331.27	115,829,702.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	131,873,231.27	114,856,602.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,744,100.00	973,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,531,144,771.90	2,074,023,947.28
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,298,956,700.00	1,749,961,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,084,944,000.00	1,056,607,300.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,145,582,700.00	679,253,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	68,430,000.00	14,100,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	232,188,071.90	324,062,847.28
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	232,188,071.90	324,062,847.28
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>14,829,750.00</u>	<u>7,499,650.00</u>
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	14,829,700.00	7,499,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	14,829,700.00	7,499,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	14,829,700.00	7,499,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	14,829,700.00	7,499,700.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(14,829,700.00)</u>	<u>(7,499,700.00)</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	50.00	(50.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	50.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	50.00	-



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	759,157,825.15	2,583,065,819.22	4,267,376.76	-	3,346,491,021.13
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	759,157,825.15	2,583,065,819.22	4,267,376.76	-	3,346,491,021.13
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	343,076,091.04	-	343,076,091.04
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	759,157,825.15	2,583,065,819.22	347,343,467.80	-	3,689,567,112.17
D01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	759,157,825.15	2,583,065,819.22	347,343,467.80	-	3,689,567,112.17
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	759,157,825.15	2,583,065,819.22	347,343,467.80	-	3,689,567,112.17
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(185,830,652.80)	-	(185,830,652.80)
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	759,157,825.15	2,583,065,819.22	161,512,815.00	-	3,503,736,459.37



2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		50.00	(50.00)	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,649,119,600.00	3,343,676,412.72	(305,443,187.28)	91.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,649,119,600.00	3,343,676,412.72	(305,443,187.28)	91.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,872,139,600.00	1,593,715,312.72	(278,424,287.28)	85.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,467,427,600.00	1,228,403,791.94	(239,023,808.06)	83.7
210101	Үндсэн цалин	818,564,800.00	797,509,621.69	(21,055,178.31)	97.4
210102	Нэмэгдэл	442,324,600.00	241,257,727.04	(201,066,872.96)	54.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	66,381,800.00	60,577,631.67	(5,804,168.33)	91.3
210104	Урамшуулал	140,156,400.00	129,058,811.54	(11,097,588.46)	92.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	184,352,800.00	150,937,374.82	(33,415,425.18)	81.9
210201	Тэтгэврийн даатгал	125,359,900.00	104,293,122.70	(21,066,777.30)	83.2
210202	Тэтгэмжийн даатгал	14,748,300.00	12,530,191.14	(2,218,108.86)	85.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,798,600.00	9,715,439.40	(2,083,160.60)	82.3
210204	Ажилгүйдлийн даатгал	2,949,600.00	2,218,056.95	(731,543.05)	75.2
210205	Эрүүл мэндийн даатгал	29,496,400.00	22,180,564.63	(7,315,835.37)	75.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	65,814,500.00	65,526,215.90	(288,284.10)	99.6
210301	Гэрэл, цахилгаан	22,133,600.00	21,958,375.52	(175,224.48)	99.2
210302	Түлш, халаалт	24,449,100.00	24,442,399.24	(6,700.76)	100.0
210303	Цэвэр, бохир ус	13,397,800.00	13,291,441.14	(106,358.86)	99.2
210304	Байрны түрээс	5,834,000.00	5,834,000.00	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	40,310,900.00	39,206,604.54	(1,104,295.46)	97.3
210401	Бичиг хэрэг	6,090,800.00	5,616,800.00	(474,000.00)	92.2
210402	Тээвэр, шатахуун	13,776,000.00	13,775,000.00	(1,000.00)	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,650,500.00	10,616,454.54	(34,045.46)	99.7
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,971,400.00	1,425,000.00	(546,400.00)	72.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,822,200.00	7,773,350.00	(48,850.00)	99.4
2105	Нормативт зардал	15,475,600.00	15,475,420.00	(180.00)	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	13,196,000.00	13,197,520.00	1,520.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,279,600.00	2,277,900.00	(1,700.00)	99.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,536,600.00	15,041,450.00	(495,150.00)	96.8
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,340,300.00	9,322,500.00	(17,800.00)	99.8
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,265,500.00	959,100.00	(306,400.00)	75.8
210604	Урсгал засвар	4,930,800.00	4,759,850.00	(170,950.00)	96.5
2107	Томилолт, зочны зардал	8,431,700.00	7,227,338.00	(1,204,362.00)	85.7
210702	Дотоод албан томилолт	8,431,700.00	7,227,338.00	(1,204,362.00)	85.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	46,099,200.00	44,278,587.52	(1,820,612.48)	96.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	36,348,100.00	36,264,494.87	(83,605.13)	99.8
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,182,100.00	627,828.00	(554,272.00)	53.1
210803	Даатгалын үйлчилгээ	1,092,200.00	1,092,200.00		100.0

210804	Тээврийн хэрэгслийн татвар	361,000.00	355,386.00	(5,614.00)	98.4
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	117,000.00	99,000.00	(18,000.00)	84.6
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,078,900.00	3,072,620.65	(6,279.35)	99.8
210807	Газрын төлбөр	820,100.00	813,008.00	(7,092.00)	99.1
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	48,500.00	50.00	(48,450.00)	0.1
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,051,300.00	1,954,000.00	(1,097,300.00)	64.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,690,700.00	27,618,530.00	(1,072,170.00)	96.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,717,600.00	26,645,430.00	(1,072,170.00)	96.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	973,100.00	973,100.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,776,980,000.00	1,749,961,100.00	(27,018,900.00)	98.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,776,980,000.00	1,749,961,100.00	(27,018,900.00)	98.5
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,059,476,000.00	1,056,607,300.00	(2,868,700.00)	99.7
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	702,227,800.00	679,253,800.00	(22,974,000.00)	96.7
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,276,200.00	14,100,000.00	(1,176,200.00)	92.3
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,649,119,600.00	3,360,823,372.72	(288,296,227.28)	92.1
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,649,119,600.00	3,343,676,412.72	(305,443,187.28)	91.6
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,649,119,600.00	3,343,676,412.72	(305,443,187.28)	91.6
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	17,146,960.00	17,146,960.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	735,000.00	735,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	16,411,960.00	16,411,960.00	-
620003	Үйлчлэх ажилтан	24.00	23.00	(1.00)	95.8
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	70.00	66.00	(4.00)	94.3



2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	138,296,822.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	138,296,822.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	136,824,172.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	43,405,465.00
210102	Нэмэгдэл	43,405,465.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,207,535.00
210201	Тэтгэврийн даатгал	3,471,315.00
210202	Тэтгэмжийн даатгал	434,055.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	347,243.00
210204	Ажилгүйдлийн даатгал	86,812.00
210205	Эрүүл мэндийн даатгал	868,110.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	88,211,172.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	88,211,172.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,472,650.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	1,472,650.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	138,296,822.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	138,296,822.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	29,683,822.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	48,613,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	60,000,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	



3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Эрүүл мэндийн газар нь эрүүл мэндийн үйлчилгээг зохицуулдаг төрийн байгууллага бөгөөд Эрүүл мэндийн газрын удирдлага, хүний нөөцийн ур чадвар, манлайллыг дээшлүүлж, чанарын менежментийн тогтолцоог үр дүнтэй нэвтрүүлэн, эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, зохион байгуулах үйлчилгээг олон улсын жишгээр хөгжүүлэх эрхэм зорилгыг дэвшүүлэн ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Хөдөлмөрийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хууль зэргийг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль зэрэг үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжуудад нэмэлт өөрчлөлтүүд орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан-Уул аймгийн Эрүүл мэндийн газрын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан-Уул аймгийн Эрүүл мэндийн газрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 172,201.8 мянган төгрөгөөр буюу 4.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	1,472.6	1,472.6
Бараа материал	619,848.4	603,948.5	(15,899.9)

Үндсэн хөрөнгө	3,069,718.7	2,906,305.5	(163,413.2)
Нийт хөрөнгө	3,689,567.1	3,511,726.6	(177,840.5)
Өр төлбөр	-	7,990.2	7,990.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,689,567.1	3,503,736.4	(185,830.7)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,689,567.1	3,511,726.6	(177,840.5)

Тайлант оны эцэст авлага данс 1,472.6 мянган төгрөгөөр өссөн нь "Элэг бүтэн Монгол" хөтөлбөрийн зарцуулагдаагүй үлдэгдлийг нэмэлт санхүүжилтийн авлагаар бүртгэснээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 15,899.9 мянган төгрөгөөр буурахад өөрийн хөрөнгөөр 115,408.8 мянган төгрөгийн материал худалдан авсан, хандиваар 663,153.9 мянган төгрөгийн материал үнэ төлбөргүйгээр хүлээн авсан, 547,258.6 мянган төгрөгийн материалыг зарцуулсан, 121,351.5 мянган төгрөгийн материалыг эрүүл мэндийн байгууллагуудад шилжүүлсэн, 125,852.5 мянган төгрөгийн материалыг акталсан нь нөлөөлжээ. Бараа материалын үлдэгдэлд эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс нь голлох үлдэгдэл байна.

Үндсэн хөрөнгө дансны хувьд тайлант онд худалдан авсан 7,499.7 мянга, ЭМЯ-аас хүлээн авсан 2,211.0 мянга, нийт 9,710.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө орлогоор бүртгэж, 173,123.9 мянган төгрөгийн элэгдэл тооцсон зэргээс шалтгаалж үндсэн хөрөнгийн дүн буурсан байна.

Тайлант онд өр төлбөр 7,990.2 мянган төгрөгөөр өсөхөд оны эцэст нэмэлт санхүүжилтийн дансны 1,472.6 мянга, тэтгэвэрт гарсан албан хаагчийн тэтгэмжийн 6,517.6 мянган төгрөгийг төвлөрүүлснээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,511,726.6 мянган төгрөг болж 177,840.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагч 2023 оны төсвийн төсөлд нийт зарлагыг 3,939,544.7 мянган төгрөгөөр тооцож, санхүүжих эх үүсвэрийг улсын төсвөөс бүрдүүлэхээр төлөвлөн дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг дээд шатны төсвийн захирагч 525,486.9 мянган төгрөгөөр бууруулан 3,414,057.8 мянган төгрөгөөр баталсан нь тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 174,627.9 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 62,309.3 мянга, эд хогшил, урсгал засварын зардал 113,714.4 мянга, эм, эмнэлгийн хэрэгслийн зардал 86,641.7 мянга, бусад зардлыг 88,193.6 мянган төгрөгөөр тус тус бууруулан баталжээ.

Харин тайлант онд Засгийн газрын тогтоолоор төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотойгоор батлагдсан төсвийг 235,061.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэх 3,649,119.6 мянган төгрөгийг 100 хувь улсын төсвөөс бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,649,119.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 3,343,676.4 мянган төгрөг зарцуулж, үлдэгдэл 305,443.2 мянга, төлөвлөөгүй орлого 17,147.0 мянга, нийт 322,590.2 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,343,676.4 мянган төгрөг буюу 91.6 хувьтай байгаа нь 8 орон тоо дутуу ажилласнаас цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 272,439.2 мянга, албан хаагчдын ажилласан хугацааг дахин тооцоолсноор хөдөө орон нутгийн албан хаагчдын дэмжлэгийн зардлыг 22,974.0 мянган төгрөгийг тус тус зарцуулаагүйтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71603- Эрүүл мэндийн бодлого, удирдлага	3,649,119.6	3,343,676.4	(305,443.2)	91.6
1.1	80101- Үндсэн үйл ажиллагааны зардал	1,837,235.8	1,558,842.5	(278,393.3)	84.8
1.2	80219- Харуул хамгаалалтын зардал	18,768.8	18,768.8	-	100
1.3	80802- Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал, дэмжлэг	1,776,980.0	1,749,961.1	(27,018.9)	98.5
1.4	83112-Хөтөлбөр төслийн дотоод урсгал зардал	16,135.0	16,104.0	(31.0)	99.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төсвийн захирагчид дээд шатны төсвийн захирагчаас “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн хүрээнд 60,000.0 мянга, аймгийн Засаг даргаас орон нутгийн 40 хувийн нэмэгдэл цалингийн санхүүжилтэд 48,613.0 мянга, Монголын сумын эмч, мэргэжилтний холбооноос сүрьеэгийн эрт илрүүлэгтэй холбоотой 22,165.2 мянга, ХӨСҮТ-ээс вакцины идэвхжилт, дэмжлэг хяналтад 2,129.0 мянга, ЭМЯ-аас МОНПЭН төсөлд 4,046.9 мянга, вакцин тээвэрлэлтийн санхүүжилтэд 1,342.7 мянга, нийт 138,296.8 мянган төгрөгийг тус тус хуваарилсныг зориулалтын дагуу зарцуулж, тайлант оны эцэст анхан шатны баримт бүрдээгүйгээс түрээс, томилолтын зардлын зарцуулаагүй үлдэгдэл 1,472.6 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэн, авлагаар тусгасан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Эрүүл мэндийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний

өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын цалингийн зардал, биет бус хөрөнгийн бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газрын аудитор Н.Отгонцэцэг гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан-Уул аймгийн Эрүүл мэндийн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 64 тоот албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны батлагдсан төсөв 3,649,119.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 36,491.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дээд шатны төсвийн захирагч 2023 оны төсвийг батлахдаа тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 174,627.9 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 62,309.3 мянга, эд хогшил, урсгал засварын зардал 113,714.4 мянга, эм, эмнэлгийн хэрэгслийн зардал 86,641.7 мянга, бусад зардлыг 88,193.6 мянган төгрөгөөр тус тус бууруулсан бол гүйцэтгэлээр бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 1,820.6 мянга, хангамж бараа материалын зардлыг 1,104.3 мянган төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 4 шалгуур үзүүлэлтээр шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулбал зохих 263 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 679,577.3 мянган төгрөгийн 3 зөрчил илэрснээс, 1,394.4 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 39,033.1 мянган төгрөгийн зөвлөмж, 639,149.8 мянган төгрөгийн албан шаардлагын хэрэгжилтийг тулган шалгахад 100 хувь хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт /мянган төгрөгөөр/		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,394.4	1	1,394.4	100.0
Албан шаардлага	1	639,149.8	1	639,149.8	100.0
Зөвлөмж	1	39,033.1	1	39,033.1	100.0
Нийт дүн	3	679,577.3	3	679,577.3	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц чухал асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд тусгагдсан 1,385.3 мянган төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй алдаа¹ илэрсэн нь УСНББОУС 19 “Нөөц, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө”, “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангаагүй тул тооцоо нийлсэн актаар баталгаажуулан залруулав.

Мөн аудитаар нийт 25,448.2 мянган төгрөгийн 7 зөрчил² илэрснээс, 3,349.7 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 22,098.5 мянган төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгөв.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар 3,394.7 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

1. Төрийн үйлчилгээний 5 албан хаагчид 1,902.1 мянган төгрөгийн орон нутагт ажилласны нэмэгдэл хөлс олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан “Төрийн үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам”-ын 2 дахь заалт,

2. Тус байгууллагын 7 албан хаагчид ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллыг 1,211.7 мянган төгрөгөөр илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

дугаар зүйлийн 16.5.5, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 3.7 дахь заалт,

3. Үйлчлэгч Б.Шүрээд удирдлагын тушаал, шийдвэргүйгээр 1 дүгээр улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулалд 235.9 мянган төгрөг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 3.10 дахь заалттай тус тус нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цалингийн зардалтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант оны 2 дугаар улирлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгохдоо ЭМГ-ын даргын 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн шинэчлэн тогтоосон цалингаар тооцоноос 8,302.2 мянган төгрөгийг илүү олгосон. Мөн үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгохдоо ажлын үр дүн, гүйцэтгэлийг сар бүр дүгнээгүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 3.2-т заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 3.2 заалтуудыг баримталж, "албан хаагчдын ажлын үр дүн, гүйцэтгэлийг сар бүр дүгнэж, тухайн улиралд нь ногдох үндсэн цалингаас тооцож олгох

1.2. Илрүүлэлт:

Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг байгууллагын хүний нөөцийн ажилтны тодорхойлолт, төсвийн шууд захирагчийн нэмэгдэл олгох тушаалд зааснаас 5,040.0 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"-ын 5 дахь заалттай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"-ын 5 дахь заалтуудыг баримталж "төсвийн шууд захирагчийн тушаал шийдвэр, хүний нөөцийн программ дахь мэдээлэлд үндэслэн төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл цалин олгох"

1.3. Илрүүлэлт:

Тайлант онд албан хаагчдад 8,756.3 мянган төгрөгийн балансын мөнгөн урамшууллыг цалингийн зардлаас олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Сангийн сайдын 2021 онд баталсан 190 дүгээр тушаал "Эдийн засгийн ангилал ашиглах заавар"-т заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Сангийн сайдын 2021 онд баталсан 190 дүгээр тушаал "Эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг баримталж "батлагдсан төсвийн хүрээнд холбогдох зардлын ангиллаас зарцуулах"

2. Биет бус хөрөнгөтэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй газрыг ГХБХБГ-аас авсан лавлагаатай тулган шалгахад 7,161.0 мкв талбайтай эзэмших эрхийн гэрчилгээтэй 6 газрыг бүртгэлд тусгаагүй байгаа нь Газрын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2-т заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Газрын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2-т заасны дагуу санхүүгийн тайланд тусгаагүй 6 газрыг үнэлж, биет бус хөрөнгөөр бүртгэх саналыг холбогдох байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэх"

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5³-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн	Тоо	Дүн
Өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуула агүй байна.	1	1,385.2	1	1,385.2	-	-	1	1,385.2	-	-	-	-
Дүн	1	1,385.2	1	1,385.2	-	-	1	1,385.2	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Төлбөрийн акт	Албан шаардлага	/мянган төгрөгөөр/		Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал
				Зөвлөмж	Үүнээс		

³ .Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
									Албан тушаалтны тоо			
Төрийн үйлчилгээний 5 албан хаагчид 1,902.1 мянган төгрөгийн орон нутагт ажилласны нэмэгдэл хөлс олгосон байна.	1	1,902.1	1	1,902.1	-	-	-	-	-	-	-	-
Тус байгууллагын 7 албан хаагчид ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллыг 1,211.7 мянган төгрөгөөр илүү олгосон	1	1,211.7	1	1,211.7	-	-	-	-	-	-	-	-
Үйлчлэгч Б.Шүрээд удирдлагын тушаал, шийдвэргүйгээр 1 дүгээр улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулалд 235.9 мянган төгрөг олгосон	1	235.9	1	235.9	-	-	-	-	-	-	-	-
Тайлант оны 2 дугаар улирлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгохдоо 3 дугаар улирлын нэмэгдсэн цалингаар тооцоолсноос 8,302.2 мянган төгрөгийг илүү олгосон	1	8,302.2	-	-	-	-	1	8,302.2	-	-	-	-
Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг олгохдоо байгууллагын хүний нөөцийн ажилтан тодорхойлолт, төсвийн шууд захирагчийн тушаалтай зөрүүтэй тооцсон.	1	5,040.0	-	-	-	-	1	5,040.0	-	-	-	-
Тайлант онд албан хаагчдад 8,756.3 мянган төгрөгийн мөнгөн урамшууллыг цалингийн зардлаас олгосон	1	8,756.3	-	-	-	-	1	8,756.3	-	-	-	-
7,161.0 мкв талбайтай 6 эзэмшлийн газрыг бүртгэлд тусгаагүй	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Дүн	7	25,448.2	3	3,349.7	-	-	4	22,098.5	-	-	-	-